

**ДАРХАН-УУЛ АЙМГААС ЭРЧИМ ХҮЧ, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ  
СҮЛЖЭЭНИЙ ТАЛААР БАРИМТЛАХ ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО**

## НЭГ.Нийтлэг үндэслэл

- 1.1. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний салбар нь Дархан хот болон сумдын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд түрүүлж хөгжүүлэх шаардлагатай суурь салбар юм.
  - 1.2. Аймгаас эрчим хүч, инженерийн шугам сүлжээний талаар баримтлах дунд хугацааны бодлогын зорилго нь өсөн нэмэгдэж байгаа эрчим хүч, усан хангамжийн хэрэгцээг тасралтгүй, найдвартай хангахад оршино.
  - 1.3. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний үйлдвэрлэл, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагаа, Дархан хот болон сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөлт, эрчим хүч, инженерийн шугам сүлжээний байгууллагуудын хэтийн төлөвлөлтийн уяалдаа холбоог сайжруулах, хөрөнгө санхүүжилтээс хамаарсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэхэд энэхүү бодлогын баримт бичгийг үндэслэл болгоно.
  - 1.4. Дархан-Уул аймгаас эрчим хүч, инженерийн шугам сүлжээний талаар баримтлах дунд хугацааны бодлогыг боловсруулах үндэслэл нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого” “Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” болно.
  - 1.5. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний өнөөгийн байдал
    - 1.5.1. Дулаан, цахилгааны эрчим хүчийг хослон үйлдвэрлэдэг эх үүсвэр болох 1965 онд ашиглалтанд орсон “Дархан дулааны цахилгаан станц” ТӨХК нь 2019 оноос өмнө цагт 48МВт буюу жилд 302,8 сая.кВт цаг цахилгааны эрчим хүч үйлдвэрлэдэг байсан. 2011-2019 онд “Эрчим хүчний үр ашиг 1” хөтөлбөрийн хүрээнд компьютерийн хяналт удирдлагын системтэй ПТ-35/39-3,4/1,0 маркын 35 МВт-ын шинэ турбин суурилуулах төслийг хэрэгжүүлэн суурилагдсан хүчин чадлаа 35 МВт-аар нэмж, цагт 83МВт буюу жилд 446,9 сая.кВт цаг цахилгааны эрчим хүч, цагт 236 Гкал буюу жилд нийт 905 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай болсон. Дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн 60 %-ийг түгээж байна.
    - 1.5.2. Цахилгаан дамжуулах сүлжээ нь Эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон зангилаа 220 кВ-н нэг дэд станц, Дархан суманд цахилгаан эрчим хүч дамжуулах зориулалт бүхий нийт суурилагдсан 122 МВА-ийн чадалтай 110 кВ-ын 4-н дэд станц, Шарын гол суманд цахилгаан эрчим хүч дамжуулах зориулалт бүхий 20МВА-ийн 110 кВ-ын нэг дэд станц байна.
- Эдгээр 110 кВ-ын таван дэд станц одоогийн бодит ачаалал 26,5 % буюу 18.71 МВт байна.  
/хүснэгт-1/

| д/д         | Дэд станцын нэр    | Суурилагдсан хүчин чадал /МВА/ | Одоо авч буй ачаалал /МВА/ | Ачаалагд аж буй хувь | Хэрэглэгч холбох нөөц гаргалгаа |
|-------------|--------------------|--------------------------------|----------------------------|----------------------|---------------------------------|
| 1           | 110/6 кВ Үйлдвэр   | 2x16                           | 3.39                       | 21%                  | байхгүй                         |
| 2           | 110/6 кВ Бурхант   | 2x25                           | 6.97                       | 28%                  | 6                               |
| 3           | 110/6 кВ Давхар    | 2x10                           | 4.75                       | 47.5%                | 4                               |
| 4           | 110/6 кВ Тосгон    | 2x10                           | 0.98                       | 9.8%                 | 1                               |
| 5           | 110/6 кВ Шарын гол | 2x10                           | 2.62                       | 26.2%                | 1                               |
| <b>Нийт</b> |                    | <b>2x71</b>                    | <b>18.71</b>               | <b>26.5%</b>         | <b>12</b>                       |

1.5.3. Цахилгаан түгээх сүлжээ: аймгийн хэмжээнд 35 кВ-ын 6 дэд станц, 6,(10)/0,4 кВ-ын 216 дэд станц, 0,4-35 кВ-ын 593,8 км агаарын шугам, 143,4 км кабель шугамтай. шинэ техник технологи нэвтрүүлэх ажил 2010 оноос хийгдэж эхэлсэн. Цахилгаан түгээх агаарын шугамыг байгаль цаг агаарын нөлөөлөлд тэсвэртэй, тасралт саатал гаргахгүй байх үүднээс бүрээстэй дамжуулагч утас ашиглаж 6-35 кВ-ын дэд станц, хуваарилах байгууламжийн тоноглолыг Герман улсад үйлдвэрлэсэн Евро стандартын хамгийн сүүлийн үеийн техникийн шийдэл бүхий тоноглолоор шинэчилсэн. 2013 оноос Түгээх сүлжээний горим, ажиллагааг хянах, бүрэн автоматжуулах ажлын хүрээнд Ухаалаг тоолуурын системийг Монгол улсад анх удаа Дархан-Уул аймагт нэвтрүүлсэн. Диспетчерийн хяналт удирдлагын автоматжуулсан систем, камерийн хяналтын систем, бүх дэд станц хуваарилах байгууламжийг СКАДА системд холбогдсон.

| Д/д | Шугам тоноглолын нэрс             | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|-----|-----------------------------------|-------------|------------|
| 1   | 35/6,(10)кВ-ын дэд станц          | ком         | 6          |
| 2   | 35кВ-ын хуваарилах байгууламж     | ком         | 1          |
| 3   | 6,(10)кВ-ын хуваарилах байгууламж | ком         | 13         |
| 4   | 6,(10)/0,4кВ-ын дэд станц         | ком         | 216        |
| 5   | 35кВ-ын агаарын шугам             | км          | 70,7       |
| 6   | 6,(10)кВ-ын агаарын шугам         | км          | 212,8      |
| 7   | 0.4кВ-ын агаарын шугам            | км          | 310,1      |
| 8   | 6,(10)кВ-ын кабель шугам          | км          | 143,4      |

Цахилгаан эрчим хүчний төлбөрийг төр хариуцах болсонтой холбоотойгоор ахуйн хэрэглэгчийн ачаалал нэмэгдэж өмнөх онтой харьцуулахад 19,87 МВт буюу 25%-аар өссөн.

1.5.4. Дулаан хангамжийн сүлжээ: “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК нь дулааны цахилгаан станцаас дулааны эрчим хүчийг худалдан авч, Ф150-Ф800 мм-ийн голчтой дулаан дамжуулах 23,1 хос км төв шугам, 91,4 хос км дулаан түгээх шугам, насосны 3 дэд станц, дулаан хуваарилах 15 төвөөр дамжуулан Дархан хотын 14 мянга гаруй айл өрх, 1600 гаруй аж ахуй нэгжүүдэд жилд дундажаар 480-550 мянган Гкал дулааны

эрчим хүч түгээдэг. Дулаан дамжуулах сүлжээний нэвтрүүлэх чадвар 228 Гкал/цаг, хэрэглэгчдийн тооцоот ачаалал 156,2 Гкал/цаг байна.

2021 оны байдлаар дамжуулах сүлжээний 23,1 метр урттай дулаан дамжуулах төв шугамын 49.2% нь 0-10 жил, 27.7% нь 11-20 жил, 11.8% нь 21-35 жил, 11.4% нь 36 ба түүнээс дээш жил болж шугамын дундаж насжилт 16 жил байна. 2021 онд 191.8 Гкал/ц байгаа бол 2022 онд дулааны ачаалал 5.7 Гкал/ц-аар, 2030 оны түвшинд 48,7 Гкал/ц-аар нэмэгдэх төлөвтэй байна.

Шарын гол сумын 12 төсвийн байгууллага, 110 аж ахуйн нэгж, 1129 айл өрхийг дулааны эрчим хүч, хэрэгцээний халуун болон хүйтэн усаар ханган бохир усыг татан зайлуулж тэдгээрийн ашиглалт, засвар үйлчилгээг үзүүлдэг. “Дулаан шарын гол” ТӨХК нь 16,8 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай DZL төрлийн 4 зуухтай, хоногт 7600 м<sup>3</sup> ус олборлох 7 гүний худаг, хоногт 3000 м<sup>3</sup> бохир ус хүлээн авч цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж, 16,8 км дулааны шугам, 17,2 км цэвэр усны шугам, 12 км бохир усны шугам хоолойг ашиглан үйл ажиллагаа явуулдаг. Өвлийн их ачааллын горимд 15,6 Гкал дулааны хэрэглээтэй болж, 4-н зуух бүрэн ачаалагдаж, нөөц тоноглолгүй ажиллаж байна.

1.5.5. Усан хангамж, ариутгах татуургын сүлжээ нь зөөврийн усан сан 18, төвлөрсөн шугамд холбогдсон 26 усан сан, гүний 18 худаг 1, 2-р өргөгч станц, 18000 м куб багтаамжтай 6-н усан сан, цэвэр усан хангамжийн 151.2 км, бохир усны 88,6 км урттай шугам, хоногт 50000 м куб бохир ус цэвэрлэх хүчин чадалтай төв цэвэрлэх байгууламж, бохир ус хүлээн авч дамжуулан шахах 3 насос станц ашиглан 1500 гаруй үйлдвэр аж ахуйн нэгж, 14000 гаруй айл өрхийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах ашиглалтын гэрээ байгуулан ажиллаж байна.

*“Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах”* Мон 3244/3245 төсөл хэрэгжиж хоногт 25000 м куб бохир ус цэвэрлэх хүчин чадалтай төв цэвэрлэх байгууламж, бохир ус хүлээн авч дамжуулан шахах 3 насос станц, . . . км урт бохир усны төв шугам өргөтгөн шинэчлэж байна.

1.6. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний тулгамдсан асуудал

1.6.1. Дулааны цахилгаан станцын үндсэн тоноглол болох ПТ-12-35/10 маркийн ТГ№1, 2, 3, 4-р турбин болон хурц уур, тэжээлийн усны шугамын баталгаат хугацаа дууссан, металлын цуцалт, элэгдэлд орж станцын найдвартай ажиллагаа алдагдах магадлал их болсон.

1.6.2. Дархан-Уул аймгийг цахилгаан эрчим хүчээр хангаж байгаа дэд станцуудын суурилагдсан хүчин чадлын ашиглалт 26,5 % байна. Хүчин чадлыг бүрэн ашиглахын тулд гаргалгааны ачааллыг зөв, оновчтой хийх шаардлага бий болж байгаагаас цахилгаан түгээх компани болон аймаг хамтарч дэд станцын гаргалгааны ачааллыг нэмэгдүүлэх зорилгоор хуваарилах байгууламж /РП/-ийг шинээр барьж байгуулах.

1.6.3. Хотын хөгжлийн ерөнхий төвлөлтийн дагуу шинэ суурьшлын бүсийн хүрээ тэлэгдэхийн хэрээр цахилгаан дамжуулах шугамын нэвтрэх чадварыг дээшлүүлэх, дамжуулах хүчдэлийн түвшинг өсгөх шаардлагатай байгаа учир цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагаа, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх өндөр хүчдэлийн тойрог схемийг байгуулах асуудал үүсэж байна.

- 1.6.4. Иргэдэд газар өмчлүүлсэнтэй холбоотойгоор аймгийн хэмжээнд шинэ суурьшлын бүсүүд бий болж цахилгаан эрчим хүчээр хангах түгээх шугам сүлжээг шинээр барих шаардлагатай байна.
- 1.6.5. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зөрчил их байгаа нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж чадахгүй, эрчим хүч, инженерийн шугам сүлжээний байгууллагуудын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.
- 1.6.6. Дархан хотын өсөн нэмэгдэж байгаа дулааны эрчим хүчний хэрэглээг хангахад дулаан дамжуулах сүлжээний 29 %-ийг өргөтгөх, 74,2 %-ийг шинэчлэх, дулааны 2 дахь эх үүсвэр шинээр барих шаардлагатай.
- 1.6.7. Шарын гол сумын ерөнхий төлөвлөгөөгөр дулааны ачаалал одоо байгаа хэрэглээ дээр 12,8 Гкал хэрэглээ нэмэгдэх тооцоолол гарч “Дулаан шарын гол” ТӨХК-ийн ашиглаж байгаа зуухны хүчин чадал хүрэлцэхгүй тул өргөтгөл, шинэчлэлт хийх шаардлагатай.
- 1.6.8. Шарын гол сумын цэвэрлэх байгууламжийг 1983 оноос ашиглаж эхэлсэн. Олон жилийн ашиглалтын явцад барилга байгууламжид их хэмжээгээр суулт үүсч ан цав бий болсон, бетон хана өгөршиж бутарсан, гол сувгууд хэв гажилтанд орсон болохоор компани өөрийн хөрөнгөөр жил бүр засвар үйлчилгээ хийдэг боловч үр дүнгүй байна.

ХОЁР. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний талаар баримтлах дунд хугацааны бодлогын алсын хараа, тэргүүлэх чиглэл, баримтлах тулгуур зарчим

- 2.1. Алсын хараа: Аймгийн эрчим хүч, инженерийн шугам сүлжээний аюулгүй байдал, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, дамжуулалт, түгээлт, хангалт хүртээмжтэй, үр ашигтай, хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологитой, ухаалаг эрчим хүч, инженерийн шугам сүлжээг бий болоход оршино.
- 2.2. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний өнөөгийн байдал, хүрсэн түвшин, тулгамдаж байгаа асуудал, хөгжлийн чиг хандлагад үндэслэн “Дархан-Уул аймгаас эрчим хүч, инженерийн шугам сүлжээний талаар баримтлах дунд хугацааны бодлого”-ын тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон:
  - 2.2.1. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний найдвартай ажиллагаа, аюулгүй байдал
  - 2.2.2. Эрчим хүч, усан хангамжийн чанар, хүртээмж, үр ашиг
  - 2.2.3. Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжил
- 2.3. Дархан-Уул аймгаас эрчим хүч, инженерийн шугам сүлжээний талаар баримтлах дунд хугацааны бодлогын зорилго, зорилтыг тодорхойлоход дараах тулгуур зарчмыг баримталсан.
  - 2.3.1. Аймгийн цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангасан байх;
  - 2.3.2. Иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлсэн байх;
  - 2.3.3. Байгаль орчинд ээлтэй байх;
  - 2.3.4. Үр ашиг, хэмнэлттэй байх;
  - 2.3.5. Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдлэгт суурилсан байх.

ГУРАВ. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний талаар баримтлах дунд хугацааны бодлогын стратегийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх зорилт

- 3.1. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний тулгамдаж байгаа асуудалд үндэслэн Дархан-Уул аймгаас эрчим хүч, инженерийн шугам сүлжээний талаар баримтлах дунд хугацааны бодлогод дараах стратегийн зорилгыг дэвшүүлж байна:

Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний найдвартай ажиллагаа, аюулгүй байдал тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

- 3.1.1. Хотын эрчим хүч, инженерийн шугам сүлжээг үе шаттайгаар шинэчлэн сайжруулна.  
3.1.2. Сумдын цэвэрлэх байгууламжийг шинээр барих, өргөтгөл, засварын ажлыг эхлүүлнэ.  
3.1.3. Гэр хорооллын зөөврийн усан санг төвлөрсөн шугамд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.  
3.1.4. Хамгаалалтын зурвасыг чөлөөлж, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх.

Эрчим хүч, усан хангамжийн чанар, хүртээмж, үр ашиг тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

- 3.1.5. Эрчим хүчний эх үүсвэрийн засвар шинэчлэлт хийх, эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.  
3.1.6. Шинэ суурьшлын бүсийг байгуулж, эрчим хүчээр хангах шугам сүлжээг үе шаттайгаар шинэчлэн сайжруулах, шинээр бий болгох.  
3.1.7. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн үйлдвэрлэлийн бүсийн инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ.  
3.1.8. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх.

Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг дэмжих

- 3.1.9. Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах.

- 3.2. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний талаар баримтлах дунд хугацааны бодлогын стратегийн зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зорилтыг дэвшүүлж байна.

3.2.1. Стратегийн нэгдүгээр зорилго: Хотын эрчим хүчний болон инженерийн шугам сүлжээг үе шаттайгаар шинэчлэн сайжруулна.

- 3.2.1.1. Дархан хотын дулаан дамжуулах шугамын худаг К27-с К39 хүртэл Ф300-350 мм голчтой 1740 хос км шугам, К27-с К35 хүртэлх Ф350 мм-ийн голчтой 1344 хос км шугам, Ф500 мм, К35-с К39 худгийн хоорондох Ф300 мм-ийн голчтой 396 хос км шугамыг Ф450 мм болгож өргөтгөх.  
3.2.1.2. 23, 25-р хорооллын дулаан хуваарилах төвийн ялтсан халаагчийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.  
3.2.1.3. Дархан хотын 20, 22-р хорооллын нийтийн зориулалттай орон сууцны 43 зангилаанд хэрэгцээний халуун усны ялтсан халаагч суурилуулах.  
3.2.1.4. Үндсэн тосгоны хэрэглэгчидэд хэрэгцээний халуун усны шугам татах, ялтсан халаагч суурилуулах.  
3.2.1.5. Хабитат хороололд инженерийн шугам сүлжээ, дулаан хуваарилах төв шинээр барих.  
3.2.1.6. Их сургуулийн гудамжинд байрлалтай дулаан хуваарилах хоёр төвийг бүрэн ачааллаж, хоёрдугаар хэлхээний шугамыг шинээр татах.  
3.2.1.7. 15-р хорооллын инженерийн шугам сүлжээ, дулаан хуваарилах төвийг шинээр барих /Хабитатын чиглэлийн Ф300 мм-ийн шугамаас огтолгоо хийх/.  
3.2.1.8. Хонгор сумын 2-р баг, Зулзагийн голын шинэ суурьшлын бүсийн айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах 6 кВ-ын 8 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 6/0.4 кВ-ын 8 дэд станц, 0,4 кВ-ын 12 км цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, 192 ш хайрцаг суурилуулах.  
3.2.1.9. Дархан хотын усан хангамжийн сүлжээний олон удаагийн давтамжтай гэмтэл гардаг 17 цэгийн 11.57 км шугам шинэчлэх

- 3.2.1.10. “Дулаан шарын гол” ТӨХК-ийн дулаан дамжуулах төвөөс К47 худаг хүртэлх түгээх төв шугамын өргөтгөл шинэчлэл хийх.
- 3.2.2. Стратегийн хоёрдугаар зорилго: Сумдын цэвэрлэх байгууламжийг шинээр барих, өргөтгөл, засварын ажлыг эхлүүлнэ.
- 3.2.2.1. Орхон сумын цэвэрлэх байгууламжийг шинээр барина.
- 3.2.2.2. Дархан хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулна.
- 3.2.2.3. Шарын гол, Хонгор сумдын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, засварын ажлыг эхлүүлнэ.
- 3.2.3. Стратегийн гуравдугаар зорилго: Гэр хорооллын зөөврийн усан санг төвлөрсөн шугамд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 3.2.3.1. Гэр хорооллын зөөврийн 18-н усан санг төвлөрсөн шугам сүлжээнд холбох
- 3.2.3.2. Дархан хотын гүний 10-н худгийг төвлөрсөн шугаманд холбох
- 3.2.4. Стратегийн дөрөвдүгээр зорилго: Хамгаалалтын зурвасыг чөлөөлж, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх.
- 3.2.4.1. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зөрчилийг арилгах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.
- 3.2.4.2. Газар олголт, дахин төлөвлөлт хийхдээ эрчим хүч, инженерийн шугам сүлжээний байгууллагуудтай зөвшилцөх.
- 3.2.5. Стратегийн тавдугаар зорилго: Эрчим хүчний эх үүсвэрийн засвар шинэчлэлт хийх, эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 3.2.5.1. Дулааны цахилгаан станцын насжилт өндөртэй тоног төхөөрөмжийг шинэчлэн солих хөрөнгийн эх үүсвэрийг шийдэж, үе шаттайгаар хэрэгжүүлэх.  
Үүнд:
- Хурц уурын шугамыг шинэчлэн солих.
  - Тэжээлийн усны шугамыг шинэчлэн солих.
  - ТГ-№1, 2, 3, 4 болох ПТ-12/35 турбиныг үе шаттайгаар шинэчлэх
- 3.2.5.2 “Дулаан шарын гол” ТӨХК-ийн дулааны станцын өргөтгөл шинэчлэл хийх
- 3.2.5.3 Цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагаа, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх өндөр хүчдэлийн тойрог схемийг байгуулах зураг, төсөв хийлгэх.
- 3.2.6. Стратегийн зургаадугаар зорилго: Шинэ суурьшлын бүс байгуулж, эрчим хүчээр хангах шугам сүлжээг үе шаттайгаар шинэчлэн сайжруулах, шинээр бий болгох.
- 3.2.6.1 11, 12-р хорооллын инженерийн шугам сүлжээг шинээр угсрах, дулаан хуваарилах төвд холбох.
- 3.2.6.2 16, 24, 31-р хороолол, Морин хуур цогцолборын хойд талын хорооллын инженерийн шугам сүлжээ, дулаан хуваарилах төв шинээр барих.
- 3.2.6.3 Орхон сумын Энхтал /Ноёнхонгор/ багийн айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах 6кВ-ын 2.1 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 6/0.4кВ-ын 250 кВА чадалтай 4 дэд станц 4, 0.4 кВ-ын 25.8 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 171 ш хайрцаг суурилуулах.
- 3.2.6.4 Хонгор сумын 1-р баг, Гурван шар Фермер хэсэгт шинээр газар олголт хийсэн 300 айл, Дархан хаалга орчмын Нарт хэсгийн 250 айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах 6/0.4кВ-ын 5 дэд станц, 6 кВ-ын 3км, 0.4 кВ-ын 3 км урт цахилгаан дамжуулах шугам барьж 112 ш хайрцаг суурилуулах.
- 3.2.6.5 Ширээн нуруунд шинээр газар олголт хийсэн 474 айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хүчээр хангахын тулд 6/0.4 кВ-ын 9 дэд станц, 6 кВ-ын 8км, 0.4 кВ-ын 21 км урт цахилгаан дамжуулах шугам барьж, 84ш хайрцаг суурилуулах
- 3.2.7. Стратегийн долоодугаар зорилго: Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн үйлдвэрлэлийн бүсийн инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ.
- 3.2.7.1 Дархан хотын үйлдвэрийн бүст байрлах дулааны худаг К80-с К93 хүртэл ф200, К93-с К94 хүртэл 250мм голчтой 1553,5 хос метр шугам шинэчлэх.
- 3.2.8. Стратегийн наймдугаар зорилго: Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх.

- 3.2.8.1. “Дархан-Ус суваг” ХК-ий алсын зайн удирдлагатай, ухаалаг тоолуурыг Дархан хотын усан хангамж, ариутгах татуургын үйлчилгээнд ашиглах
- 3.2.8.2. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний байгууллагуудын үйл ажиллагааны удирдлага, хяналт, мэдээллийн системийг тоон системд шилжүүлэх, ухаалаг сүлжээг бий болгох.
- 3.2.9. Стратегийн есдүгээр зорилго: Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах.
  - 3.2.9.1. Айл өрх, аж ахуйн нэгж, алслагдсан суурин, баг, бие даасан хэрэглэгчийн эрчим хүчний хангамжид нар, салхи, биомасс, шингэн болон хийн түлш, газрын гүний дулаан, түлшний элемент, бусад шинэ эх үүсвэрийг ашиглах.
  - 3.2.9.2. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний байгууллагуудын үйл ажиллагааны байгаль орчин, экологид үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах.

**ДӨРӨВ.** Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

- 4.1. Дархан-уул аймгаас эрчим хүч, инженерийн шугам сүлжээний талаар баримтлах дунд хугацааны бодлогыг Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл хэрэгжих хугацаанд хэрэгжүүлнэ.
- 4.2. Хүрэх үр дүн: Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, эрчим хүч, инженерийн шугам сүлжээний байгууллагуудын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх.
  - 4.2.1. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээг сэргээн засварлах, нөхөн сэргээх зардалын сан байгуулах.
  - 4.2.2. Дулаан дамжуулах шугамын өргөтгөл шинэчлэлт, 20, 22-р хорооллын нийтийн зориулалттай орон сууцны байр болон үндсэн тосгоны хэрэгцээний халуун усны шугам татах ажил хийнэ.
  - 4.2.3. Дархан сумын 15-р хороолол, Хабитат хорооллын дулаан хуваарилах төв, Их сургуулийн гудамжны II хэлхээний шугам шинээр хийнэ.
  - 4.2.4. Орон нутаг болон хувийн хэвшил хамтран Хонгор сумын 2-р баг Зулзагийн голын айл өрх цахилгаан эрчим хүчээр хангагдсан байна.
  - 4.2.5. Дархан хотын усан хангамжийн сүлжээний гэмтэл их гардаг шугамын шинэчлэл хийнэ.
  - 4.2.6. Сумдын цэвэрлэх байгууламжийг шинээр барих, өргөтгөл, засварын ажил хийгдсэн байх.
  - 4.2.7. Гэр хорооллын зөөврийн 10-н усан сан төвлөрсөн шугамд холбогдох.
  - 4.2.8. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зөрчилийг арилгах эхний үе шатны ажил хийнэ.
  - 4.2.9. Газар олголт, дахин төлөвлөлт хийхдээ эрчим хүч, инженерийн шугам сүлжээний байгууллагуудтай зөвшилцөх.
  - 4.2.10. “Дархан Дулааны цахилгаан станц” ТӨХК, “Дулаан шарын гол” ТӨХК-ийн дулааны станцын тоног төхөөрөмжийг шинэчлэх үе шатны ажил хийх.
  - 4.2.11. Шинэ суурьшлын бүсийг эрчим хүчээр хангах шугам сүлжээ шинээр бий болгох.
  - 4.2.12. Үйлдвэрлэлийн бүсийн инженерийн дэд бүтэц сайжирна.
  - 4.2.13. Дархан хотын усан хангамжийн систем бүрэн ухаалаг тоолууртай болох, эрчим хүч, инженерийн шугам сүлжээний байгууллагуудын үйл ажиллагаанд удирдлага, хяналтын цахим систем нэвтэрсэн байх.
  - 4.2.14. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний байгууллагуудын ашигт ажиллагаа өсөн нэмэгдэх.
  - 4.2.15. Эрчим хүч үйлдвэрлэл, дамжуулалт түгээлтийн үйл ажиллагаанд эрчим хүчний хэмнэлт хийж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан байх

ТАВ. Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

- 5.1. Дархан-уул аймгаас эрчим хүч, инженерийн шугам сүлжээний талаар баримтлах дунд хугацааны бодлого хэрэгжүүлэх арга хэмжээ нь Улсын болон Орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.
- 5.1.1. Улсын болон Орон нутгийн төсөв;
  - 5.1.2. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа;
  - 5.1.3. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
  - 5.1.4. Олон улсын санхүүгийн байгууллагын дэмжлэг;
  - 5.1.5. Зээл, тусламж
  - 5.1.6. Бусад эх үүсвэр.